

## ДЭЛХИЙН ДЭГ ЖУРМЫН ӨӨРЧЛӨЛТ БА МАКИАВЕЛЛИЙН УЛС ТӨРИЙН РЕАЛИЗМ

П.Мягмардорж\*

“Дайны урлаг, дайтахуйн ухаанаас илүүтэй Эзэн дээдсийн санаа бодлыг чилээх, анхаарлаа хандуулах нэгээхэн зүйл үгүй”

Н.Макиавелли. “Эзэн дээдэс”<sup>44</sup>

***Abstract:** In the discipline of International Relations there are two main controversial theories or theoretical views. Realism, which emphasizes international relations as eternal chaos because of its immoral actors who value only power and authority. Realism often denies idealism; theoretical school which stresses that in international relations, perpetual peace is established through moral norms and principles. The debate between realist and idealist theories has been going on for many years now, almost since the end of the First World War. By the end of the Cold War, after the collapse of the Soviet Union large number of idealist theorists saw the triumph of the USA and its liberal democracy that would replace human conflict with Universal Peace. However, today we see that the foreign policy of the main actors in the international relations has been strongly dependent on political realism. Decision makers of many nations and super powers have been appraising the power and authority. Contemporary political leaders do not give importance to moral principles and norms. Therefore, they act and make a decision without any moral principles. This paper's main goal is to understand contemporary world political decision making practice and moral norms of political leaders by analyzing Machiavelli's "Prince".*

***Key words:** Necessita, Fortuna, the Nature of Power, Political reality versus Morality, pretend to be Moral, Immoral Politicians, The Art of War.*

\* \* \*

Үзэл баримтлалын хувьд эрс тэрс ялгаатай реализм ба идеализм нь олон улсын харилцааны шинжлэх ухааны үндсэн хоёр онолын дэг сургууль юм. Реализмын онолын төлөөлөгчид олон улсын харилцааны үндсэн оролцогчид ёс суртахуунгүй, зөвхөн эрх мэдэл, хүч чадавхийг эрхэмлэдэг тул олон улсын харилцаа нь мөнхийн сөргөлдөөнт байдалд оршдог гэж үздэг бол идеализмын онолын төлөөлөгчид ёс суртахууны хэм хэмжээ, суурь зарчмуудын хүрээнд “үүрдийн энх тайван” байдал тогтоож болно хэмээн нотолдог. Энэхүү хоёр онолын дэг сургуулийн хоорондын үзэл санааны маргаан Дэлхийн I дайнаас эхлэн өнөөг хүртэл үргэлжилсээр байна.

\* ХИС-ийн ОУХНСС-ийн ОУХНС-ын тэнхимийн багш, докторант.

<sup>44</sup> Н.Макиавеллигийн уг бүтээлийг монгол хэлнээ “Принц: засаглахуйн шастир”, “Хунтайж”, “Их Эзэнтэн” “Эзэн хаан” гэх мэтээр оноон орчуулсан байдаг. Энэхүү өгүүлэлд орчуулагч Ч.Баатарын “Эзэн дээдэс” хэмээн хөрвүүлсэн хувилбараар оруулсан болно.

Хүйтэн дайн дуусч ЗХУ задран унаснаар идеализмын онолын олон төлөөлөгчид АНУ-ын ялалтын үр дүнд либераль ардчилсан үнэт зүйлс олон улсын үнэт зүйл болж улмаар даян дэлхийд энх тайван тогтох болно хэмээн дүгнэх болсон юм. Гэсэн хэдий ч өнөөгийн олон улсын харилцааны гол оролцогчдын гадаад бодлого дахин реалист шинж чанартай болж реализмын онолын дэг сургуулийн байр суурь олон улсын харилцааны шинжлэх ухаанд эргэн сэргэж байна. Нилээд тооны улс орнуудын гадаад бодлогын шийдвэр гаргагчид олон улсын харилцаан дахь байр сууриа сэргээх зорилгоор эрх мэдэл, хүч чадавхийн төлөөх тэмцэлд оролцох боллоо. Өнөөгийн улс төрийн олонх лидерүүд дээрх зорилгодоо хүрэхийн тулд ёс зүйн хэм хэмжээг үл тоон улс төрийн шийдвэр гаргах байдал ихээр ажиглагдаж байна.

Энэхүү судалгааны өгүүлэлийн үндсэн зорилго нь Италийн сэргэн мандалтын үеийн улс төрийн сэтгэгч Н.Макиавеллигийн “Эзэн дээдэс” хэмээх бүтээлийн үзэл санаанд дүн шинжилгээ хийх замаар өнөөгийн дэлхийн улс төрийн бодлого, тэр дундаа шийдвэр гаргагчдын ёс суртахууны төлөв байдалд үнэлэлт хийхэд оршиж байна.

Өнөөдөр олон улсын харилцааны судлаачдын анхаарал татаж буй сэдвийн нэг нь АНУ-ын цэрэг стратеги, эдийн засаг, соёл иргэншлийн давамгайлал хумигдаж II дайны дараа тогтсон дэлхийн дэг журам өөрчлөгдөж буй тухай асуудал болж байна. Хүйтэн дайны төгсгөлд Зөвлөлт Холбоот Улс задран, коммунист тогтолцоо нуран унаснаар Америкийн Нэгдсэн Улс дэлхийн цорын ганц хэт их гүрний статустай үлдэж олон улсын харилцаа нэг туйлт системд шилжин олон улсын энх тайван аюулгүй байдал АНУ-ын үзэмжээр тогтох болсон талаар судлаачид дүгнэн бичих болсон. Олон улсын харилцааны онолын сургуулиудын маргаанд либераль онолын талынхан давамгайлах болж, Германы философич И.Кантын зөгнөн бичиж байсан ёс суртахуун, эрх зүйд тулгуурласан “*Үүрдийн амар амгалан*”<sup>45</sup> тогтох боломжтойг тунхаглан зарлах болсон билээ.

Дэлхийн хөгжил дэвшил, шинэ зууны өнгө төрхийг барууны либераль-ардчилал тодорхойлох ёстой хэмээн үзэж байсан АНУ-ын улс төрийн шийдвэр гаргагчид олон улсын харилцаанд “Америкийн энх тайван” (*Pax Americana*) тогтоохоор зориг шулуудацгаав. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд АНУ өөрийн чөлөөт зах зээлийн эдийн засгийн загвар болон улс төрийн засаглалын хэлбэрийг Соросын Сан, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан, Олон Улсын Бүгд Найрамдахчуудын Хүрээлэн, Үндэсний Ардчилалын Хүрээлэн гэх мэт байгууллагуудаар дамжуулан бусад улсад тулгах болсон. Хүйтэн дайны сөргөлдөөнд коммунист тогтолцоог нурааж, ялалт байгуулсан цэрэг улс төр, эдийн засаг, соёл иргэншлийн асар их хүч чадавх, нөлөө бүхий АНУ нь бусад улсын хувьд ялангуяа пост коммунист улсуудын хувьд яахын аргагүй цаашдын хөгжлийн загвар, даган дуурайх үлгэр жишээ болсон билээ. “Ардчиллын 3 дахь давалгаа”-ны үр дүнд ардчилсан үнэт зүйлс дэлхий даяар тархаж АНУ-ын либераль-ардчилал дэлхийн цорын ганц

<sup>45</sup> Immanuel Kant. Perpetual Peace: A Philosophical Sketch. 1795

хөгжлийн загвар болсноор хүн төрөлхтөний мөргөлдөөний түүх өндөрлөх тухай Америкийн эрдэмтэн Ф.Фукуяама “Түүхийн төгсгөл ба сүүлчийн хүн” бүтээлээрээ илэрхийлсэн юм.

Гэвч энэ нь бодит байдалтай нийцэхгүй болох нь өнөөгийн олон улсын харилцаанд өрнөж буй үйл явдлаас харагдаж байна. Ази, Африк, Латин Америкийн олон оронд авторитар болон тотилатар дэглэмүүд хүчээ авч буй төдийгүй Европын зарим улсад хэт барууны, үндсэрхэг улс төрийн хүчнүүд хууль тогтоох байгууллагад суудал эзлэх болж улс төрийн шийдвэр гаргалтад хүчтэй нөлөө үзүүлэх боллоо. Либераль-ардчилсан засаглалын хэлбэрийг үнэлэх үнэлэмж унахын зэрэгцээ олон улсын чөлөөт эдийн засгийн тогтолцоонд ч хүндрэл бэрхшээл бий болж байна. Дэлхийн II дайны дараа Америкийн үзэмжээр тогтсон “Вашингтоны зөвшилцөл”-ийг БНХАУ-ын эрх баригчид “Бээжингийн зөвшилцөл”-өөр солих хүсэлтэй буйгаа ил тодоор зарлах болов. Даяаршил ба эдийн засгийн интеграцчлалын эсрэг тэмцэл хөгжиж буй орнуудад төдийгүй хөгжингүй орнуудад ч өрнөж байна. Технологийн өндөр хөгжилтэй уялдан ажлын байрны хүрэлцээ, үнэлэмж буурах хандлага хөгжингүй орнуудын аж үйлдвэрийн салбарт ажиглагдах болсон ба хүн амын насжилттай холбоотойгоор нийгмийн халамж үйлчилгээний зардал эдгээр улсын засгийн газрын томоохон асуудал болж байна.

Нийгэм, эдийн засгийн асуудлуудаас гадна барууны улсуудын шийдвэр гаргагчдын санааг зовоож буй өөр нэг зүйл нь цагаач, дүрвэгсэдийн асуудал юм. Ойрхи Дорнодын хямрал мөргөлдөөнөөс үүдэлтэй дүрвэгсэдийн давалгаа нь Европын Холбооны төдийгүй Хойд Америкийн улсуудын засаг захиргаа, ард түмний хооронд үл ойлголцолыг үүсгээд байгаа төдийгүй Европын Холбооны гишүүн улсуудын хооронд байр суурийн томоохон зөрчилдөөнийг бий болгож байна. Эдгээр болон бусад нийгэм эдийн засгийн олон арван асуудлууд олон нийтийн санаа бодлыг өөрчилж ардчиллын үнэт зүйлийг бэхжүүлэх гэхээс илүүтэй улс төр, эдийн засгийн популизм, үндсэрхэг үзлийг дэвэргэх болжээ. Үр дүн нь Брексит (Brexit), АНУ-ын ерөнхийлөгчийн сонгууль, Каталаны Испаниас салан тусгаарлах тэмцэл, Польшийн үндсэрхэг үзэлтнүүдийн жагсаал, ЕХ-ны талаар баримталж буй өнөөгийн Унгарын засгийн газрын байр суурь зэргээр илэрч байна.

Олон улсын энх тайван, аюулгүй байдлын асуудалд ч тодорхой бэрхшээлүүд бий болж байна. Бүс нутгийн халуун цэгүүдэд энх тайван тогтоох зорилгоор “дэлхийн цагдаа”-гийн үүргийг өөртөө авсан АНУ-ын цэргийн ажиллагаа сүүлийн үед дараа дарааллан бүтэлгүйтэж буйг Афганистан, Ирак, Ливи, Сири дэх нөхцөл байдлаас харж болно. Дэлхийн амар амгалан, энх тайвныг сахин хамгаалах зорилгоор байгуулагдсан Нэгдсэн Үндэсний Байгууллага ч Ойрхи Дорнодын хямрал, Хойд Солонгос, Иран зэрэг улсуудын цөмийн зэвсгийн хөтөлбөр, их гүрнүүдийн жижиг улсын бүрэн эрхт байдал болон газар нутгийн бүрэн бүтэн байдлын эсрэг хийж буй үйлдэл зэрэг олон асуудлаар үндсэн үүргээ биелүүлж чадахгүй байгааг улс төрчид шүүмжлэхийн зэрэгцээ олон улсын улс төр, аюулгүй байдлын чиглэлээр судалгаа

хийдэг судлаачид дүгнэн бичиж НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэлийн талаар санал бодлоо илэрхийлэх боллоо.

Дэлхийн эдийн засаг, улс төрийн өнөөгийн нөхцөл байдлыг ажиглаж дүгнэлт хийвээс олон улсын харилцааны системд томоохон өөрчлөлт орох нь гарцаагүй болсон байна. Олон улсын харилцааны реалист сургуулийн нэрт төлөөлөгч АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга асан Хенри Киссенжер 2014 онд хэвлүүлсэн *“Дэлхийн Дэг Журам: Түүхийн явц ба Үндэстнүүдийн зан төлвийн талаарх эргэцүүлэл”* хэмээх бүтээлдээ: олон улсын харилцааны систем солигдох үед олон улсын аюулгүй байдал ноцтой аюул заналтай тулгардаг гээд **“олон улсын харилцааны оролцогчдын хоорондын зааг хязгаар үгүй болж олон улсын харилцааны тавцан нь дэлхийн улс төрийн бодлого дахь байр сууриа шинээр тодорхойлохыг зорьсон асар их зөрчил бүхий тоглогчдын тоглоомын талбар болон хувирдаг”**. **“Энэхүү эмх замбараагүй байдал нь шинэ систем тогтох хүртэл үргэлжилнэ”**<sup>46</sup> хэмээн нотолсон байна.

Өнөөдөр олон улсын харилцааны үндсэн оролцогчдын гадаад бодлогод реализмын онол хүчтэй нөлөөлж улмаар дэлхийн улс төрийн бодлогод ёс суртахууны хэм хэмжээ алдагдах болсон. Энэхүү өгүүллийн үндсэн зорилго нь улс төрийн шийдвэр гаргалт, ялангуяа улс төрчдийн ёс суртахууны хэм хэмжээнд дүн шинжилгээ хийхэд оршиж байна. Иймийн тулд олон улсын харилцааны онолын дэг сургуулиуд, тэр дундаа реализмын онолын дэг сургуулийн философийн түүхэн уламжлалыг судлах шаардлагатай. Ялангуяа улс төрийг ёс суртахуунаас зааглаж авч үзсэн сэргэн мандалтын үеийн агуу сэтгэгч Италийн философич Н.Макиавеллигийн “Эзэн дээдэс” хэмээх бүтээлийг судалж уг бүтээлийн өнөөгийн дэлхийн улс төрийн бодлогод үзүүлж буй бодит нөлөөнд дүн шинжилгээ хийхийг зорьсон болно.

### Үндсэн хэсэг

Олон улсын харилцааг судалж түүнд үнэлэлт дүгнэлт хийдэг улс төрийн шинжлэх ухааны гол салбар бол олон улсын харилцааны онолын судалгаа юм. Энэхүү салбар шинжлэх ухааны үүсэл хөгжлийг дэлхийн I дайны дараагаас авч үздэг. Хүн төрөлхтөнийг бараг бүхэлд нь хамарсан, урьд өмнө нь дэлхийн түүхэнд тохиож байгаагүй ихээхэн хэмжээний үхэл зовлон, санхүүгийн хохирол дагуулсан дайн гарсан нь тухайн үеийн эрдэмтэд, улс төрчдийн хувьд улсуудын харилцаа, ялангуяа улс хоорондын дайн ба энхийн асуудал нь онолын түвшинд шинжлэх ухаанчаар судалбал зохих нэн тулгамдсан асуудал болсон билээ. Ийнхүү дайн яагаад гардаг, түүнийг хэрхэн урьдчилан сэргийлж болох тухай асуудалд судлаачид, улс төрийн шийдвэр гаргагчид анхаарлаа хандуулах болсноор идеализмын онол олон улсын харилцааны анхдагч онолын сургууль болжээ.

Гэвч дэлхийн I дайны дараа тогтсон ОУХ-ны системийг<sup>47</sup> эвдэхээр “Тэнхлэг”-ийн улсууд эвсэж дэлхийн II дайныг эхлүүлснээр идеализмын онолд томоохон

<sup>46</sup> Hillary Clinton reviews Henry Kissinger’s “World Order”. The Washington Post., September 4, 2014

<sup>47</sup> ОУХ-ны Версаль-Вашингтоны систем.

цохилт болж үндэстэн улсын хувьд **үндэсний ашиг сонирхол, хүч чадавх** чухал хэмээн номлодог реализмын талын судлаачид олон улсын харилцааг судлах онолын шинэ дэг сургуулийг гаргаж ирэв. **Улс төрийн нэгжүүдийн** (гол нь үндэстэн улсууд) **хоорондын харилцаа нь ашиг сонирхлын зөрчил ба үүнээс үүдэн олон улсын харилцаанд сөргөлдөөн, хямрал мөргөлдөөн, дайн дажин буюу “эмх замбараагүй байдал” мөнхийн шинжтэй** хэмээн энэхүү онолын талынхан дүгнэдэг.

Иймд олон улсын улс төрийн нөхцөл байдлыг **ёс суртахуун, хууль эрх зүйн хүрээнд явагдах ёстой “хамтын ажиллагаа”** хэмээн тодорхойлдог идеализм буюу либерал онолтой реализмын сургууль үзэл баримтлалын хувьд ихээхэн зөрчилдөөнтэй байдаг.

Олон улсын харилцааны шинжлэх ухааны онолын хэд хэдэн маргаан байдаг ба анхдагч маргаан буюу олон улсын харилцааг судлан тайлбарлах реализм ба идеализмын онолын байр суурийн зөрчил<sup>48</sup> 1930-аас 40-өөд оны үеэс эхэлсэн<sup>49</sup> бөгөөд өнөөдрийг хүртэл уг маргаан үргэлжилсээр байна.

Хүйтэн дайны дараа АНУ-ын тэргүүлсэн “Дэлхийн Шинэ Дэг Журам” тогтсоноор олон улсын харилцааны онолын судалгаанд либераль-идеалист онолын талынхан давамгайлах болсон. Харин өнөөгийн дэлхийн бодлого, олон улсын харилцаанд гарч буй хүчний тэнцвэрийн өөрчлөлт, эрх мэдлийн төлөөх тэмцэл нь реализмын онолын дэг сургуулийг ихээхэн үндэслэлтэй болохыг нотлож буй үйл явдал юм.

Реалистууд олон улсын харилцааны үндсэн оролцогч нь улс гэж үзээд эдгээр **улс оролцогчид нь үндэсний ашиг сонирхол болон аюулгүй байдлаа хангаж эрх мэдэл, хүч чадавхаа нэмэгдүүлэн, олон улсын харилцаан дахь байр суурь, нэр нөлөөгөө өсгөхийг зорьдог** болохыг олон талаар нотолдог.

Реализм нь өнөөдрийн сонгодог онол болтлоо маш урт түүхэн хугацааг туулсан ба янз бүрийн үзэл номлолуудаар баяжиж иржээ. Энэ онолын урсгалын үндэслэгч хэмээн тооцогддог эрхмүүдийн дотроос эртний Грекийн түүхч Фукидид, сэргэн мандалтын үеийн болон соён гэгээрлийн үеийн сэтгэлгээний агуу төлөөлөгчид болох Никколо Макиавелли, Томас Гоббс, Эмерик де Ватель, Карл фон Клаузевиц нарын нэрс тодоор бичигддэг. Эдгээр сэтгэгчдийн улс хоорондын харилцааг үнэлж дүгнэсэн дүгнэлтийг сонгодог онолын төвшинд хөгжүүлсэн судлаачид бол ХХ зууны эхэн хагаст барууны улс төрийн реалист онолын голлох төлөөлөгчид хэмээгдэж байсан Эдуард Карр, Рейхольд Найбур, Ханс Моргентау нар юм. Тэгвэл сонгодог реализмын онол нь 1970-80-аад оны үеэс Кеннет Уолц, Жон Миршаймер гэх мэт АНУ-ын нэр хүнд бүхий судлаачид төлөөлдөг неореализмын онолын урсгалд байр сууриа тавьж өгсөн бөгөөд неореализмын түвшинд реализмын

<sup>48</sup> Lucian M. Ashworth, Did the Realist-Idealist Great Debate Really Happen? A Revisionist History of International Relations, Vol. 16, No. 1, 33-51 (2002)

<sup>49</sup> Ken Booth, Micheal Cox and Timothy Dunne, *The Eighty Years Crisis: International Relations: 1919-1999*, (Cambridge: Cambridge University Press, 1998), Issue 1, p1.

онол нь илүү шинжлэх ухаанч байдлаар олон улсын харилцааг задлан шинжилж, үнэлэлт дүгнэлт өгч байна.<sup>50</sup>

Сонгодог реализм болон неореализмын онолын сургууль нь олон улсын харилцааны либерал-идеалист онолын сургууль төдийгүй 1950-60-аад оноос олон улсын харилцааны онолын судалгаанд шинжлэх ухаанч хандлагыг дэлгэрүүлсэн шинжлэх ухааны модернист (*бихевиорист*) болон 1990-ээд оны сүүлээр хүчээ авсан конструктивист онолын төлөөлөгчдийн зүгээс ихээхэн шүүмжлэл хүлээдэг. Гэсэн хэдий ч реализмын онол нь олон улсын харилцааны онолын сургуулиуд дотор хамгийн нөлөө бүхий онол гэдэг байр сууриа хадгалсаар байна. Өнөөгийн олон улсын харилцаанд үүсээд буй нөхцөл байдал нь реализмын онолын сургуулийн философи сэтгэлгээний уламжлалт төлөөлөгчдийн бүтээлийг анхааран судлах шаардлагыг бий болгож байна. Ялангуяа ёс суртахууны хэм хэмжээг олон улсын улс төрийн тавцанд хэрэгсэхээ больж “**үндэсний ашиг сонирхол**” улсуудын хувьд нэн чухалд тооцогдон улмаар эрх мэдлийн төлөөх тэмцэл олон улсын харилцаанд хүчтэй өрнөж буй үед реализмын онолын философи сэтгэлгээний уламжлалын гол бүтээлүүдийн нэг Н.Макиавеллигийн “Эзэн дээдэс”-ийг задлан шинжлэхэд огтоос буруудахгүй билээ.

Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны эцэг<sup>51</sup> хэмээн тооцогддог сэргэн мандалтын үеийн Италийн улс төрч, дипломатч, түүхч, философич Никколо Макиавеллигийн 1513 онд бичсэн “Эзэн дээдэс” хэмээх бүтээл нь улс төрийн реализмын онолын чухал эх сурвалж, мөн томоохон судлагдахуун болсоор ирсэн билээ. Өнөөгийн олон улсын харилцааны голлох оролцогчдын ашиг сонирхол, тэдгээрийн улс төрийн шийдвэр гаргагчдын зан төлөвийг судлахад уг бүтээл томоохон хувь нэмрээ оруулах ёстой. Учир нь Макиавеллигийн бүтээл нь улс төр ба ёс зүйн харилцан хамаарлыг судалсан чухал судалгаа төдийгүй эрх мэдэлд хүрэх арга зам, эрх мэдлээ хадгалж үлдэх талаар улс төрийн шийдвэр гаргагчдад өгсөн үнэ цэнэтэй зөвлөгөө юм.

Монгол хэлнээ “Эзэн дээдэс” хэмээн буулгасан Ч.Баатарын орчуулгын бүтээлийн ерөнхий редактор, профессор С.Одхүү уг бүтээлийн удиртгалын хэсэгт: “*Макиавелли нь улс төрийн шинжлэх ухааны судлагдахуун нь засаг, засаглал, судалгааны арга нь ажиглалт хэмээн тодорхойлж, улс төрийн үндсэн зарчмуудыг томъёолж, улс төрийн үйл явцыг ангилан зааглаж, эзэн дээдсийн нэр төр, сүр хүчинд нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулж, улс төрийг ёс суртахуун, шашнаас ангид авч үзэхийн чухлыг онцолж, үндэсний эв нэгдлийн үзэл санааг дэвшүүлж, засаглалын хуваарь, чиг үүргийг зааж, улс төрийн үйл ажиллагааны зүй тогтол, учир холбогдол, холбоо хамаарлыг тодотгохыг зорьж байсныг судлаачид зүй ёсоор үнэлдэг*”<sup>52</sup> хэмээн дүгнэн бичжээ.

<sup>50</sup> П.Мягмардорж. “Фукидидын “Пелопонессийн дайны түүх” ба улс төрийн реализм”. ХИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. УБ. 2016 он.

<sup>51</sup> Mikko Lahtinen, *Politics and Philosophy: Niccolo Machiavelli and Louis Althusser's Aleatory Materialism* (Leiden: Brill, 2009), 115-116.

<sup>52</sup> Н.Макиавелли. “Эзэн дээдэс”, орч. Ч.Баатар. Монсудар. УБ., 2015 он. vii-viii



Америкийн улс төрийн философич, Харвардын Их Сургуулийн профессор Харви Менсфильд Макиавеллигийн “Эзэн дээдэс” хэмээх бүтээлийн талаар: “Улс төрийн талаар бичигдсэн бүх цаг үеийн хамгийн алдартай бүтээл”<sup>53</sup> хэмээн үнэлсэн бол Америкийн улс төр судлаач, газарзүйч Жаред Даймонд 2013 онд “Нью Йорк Таймс” сонинд өгсөн ярилцлагадаа “хэрэв АНУ-ын ерөнхийлөгч цорын ганц ном унших ёстой бол тэр нь Макиавеллигийн “Принц” байх болно. Учир нь Макиавелли эрх мэдлийн хил хязгаар болоод түүнийг хэрхэн яаж ашиглахыг тодорхойлж өгсөн гайхалтай реалист юм”. “Улс төрийн шийдвэр гаргагчид төдийгүй улс төр судлаачид Макиавеллиг заавал унших ёстой”<sup>54</sup> гэсэн байна.

Стэнфордын их сургуулийн профессор, Италийн уран зохиол судлаач Роберт Харрисон Макиавеллигийн талаар: “Макиавеллигийн өмнөх үеийн сэтгэгчид улс төрийг онолын хувьд заавал ёс зүйтэй холбон тайлбарладаг байв. Тухайлбал эртний Грекийн философич Аристотель улс төрийг ёс зүйн нэг салбар хэмээн үзээд ёс зүй нь хувь хүний ёс суртахууны төлөв байдлаар тодорхойлогддог бол улс төр нь зохион байгуулалттай нийгмийн бүлэг, хүмүүсийн ёс суртахууны хэм хэмжээгээр тодорхойлогддог хэмээн үзсэн. Харин Макиавелли улс төрийг ёс зүйгээс салган авч үзсэн бөгөөд эндээс улс төрийн шинжлэх ухаан бие даасан шинжлэх ухаан болон хөгжсөн”. “Макиавеллигийн “Принц” хэмээх бүтээлийн талаар нэмэж хэлэхэд Хенри Киссинжер болон Ричард Никсон нар унтахын өмнө энэ бүтээлийг заавал уншдаг байсан”<sup>55</sup> хэмээжээ.

Олон Улсын Харилцааны Зөвлөл<sup>56</sup> судалгааны хүрээлэнгийн Олон Улсын Институтын хөтөлбөрийн ахлах судлаач бөгөөд захирал Стьюарт Патрик “Национал Интерес” сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэлдээ “Фукидидаас Гоббс, Моргентаугаас Мишаймер хүртэлх бүхий л реалист уламжлалын төлөөлөгчдөөс гагцхүү Макиавелли л уншигчдыг гайхируулан алмайруулсаар байх болно”<sup>57</sup> хэмээснээс үзэхэд Макиавеллигийн “Эзэн дээдэс” нь түүхийн бүхий л цаг үеийн улс төрийн бодлого, улс төрчдийн үзэл баримтлал, улс төрийн философийг ойлгоход чухал нөлөө бүхий бүтээл болж таарч байна.

Никколо Макиавелли нь 1469 онд тухайн үеийн Италийн Флоренцийн хотулсад төрсөн ба Флоренцийг захирч байсан Медичийн гэр бүлийнхэн 1494 онд эрх мэдлээ алдаж Флоренцийн Бүгд Найрамдах Улс байгуулагдахад Флоренцийн төрд алба хашиж эхэлсэн ба 4 жилийн дараа тус улсын гадаад харилцаа, дипломат ажиллагааг удирдан явуулах эрх бүхий албан тушаалд томилогдсон байна. 1512 онд Медичийн гэр бүлийнхэн эрх мэдлээ дахин сэргээж Флоренцийг засаглах

<sup>53</sup> Harvey C. Mansfield, *Introduction to the Prince by Niccolò Machiavelli*, (Chicago: University of Chicago Press, 1988), vii.

<sup>54</sup> “Jared Diamond: By the book,” *New York Times*, accessed January 17, 2013, <https://www.nytimes.com/2013/01/20/books/review/jared-diamond-by-the-book.html>.

<sup>55</sup> Robert P. Harrison, “What can you learn from Machiavelli?” *Yale Insights*, January 11, 2011, <https://insights.som.yale.edu/insights/what-can-you-learn-machiavelli>.

<sup>56</sup> Council on Foreign Relations

<sup>57</sup> Stewart Patrick, “Machiavelli: still shocking after 5 centuries,” *The National Interest*, November 20, 2014, <https://nationalinterest.org/commentary/machiavelli-still-shocking-after-five-centuries-9126>.

болсны дараа жил нь буюу 1513 оны 2 сарын 18-нд Макиавеллиг баривчлан шоронд хорьсон байна.<sup>58</sup> Улс төрийн амьдралаас холдон хөдөө тосгонд цөлөгдсөн тэрбээр **“Гэгээн дээдэс Лоренцо де Медичид”** хэмээн хаяглан захидал маягаар **“Эзэн дээдэс”** хэмээх бүтээлээ туурвисан ба уг бүтээлдээ эзэн хаад эрх мэдлээ хадгалахын тулд юу хийх ёстой, хэрхэн засаглах ёстойг дэлгэрэнгүй судлан, улс төрийн түүхэн үйл явцад задлан шинжилгээ хийж, дүгнэн цэгнэж өөрийн цаг үеийн болон ирээдүйн эзэн хаадад зөвлөгөө болгон бичжээ.

Макиавеллигийн үеийн болон түүнээс өмнөх үеийн олон арван сэтгэгчид ёс суртахуунт хүн бурхны хишгийг хүртэх бөгөөд ёс зүйтэй эзэн хаад энэ насандаа төдийгүй дараагийн амьдралдаа ч амжилттай байж диваажинд хүрэх тухай бичиж байсан. Харин Макиавелли уг үзэл баримтлалтай санал нийлээгүй төдийгүй эзэн хаад худал хэлж хууран мэхлэн, эрх мэдлээ хадгалахын тулд хүч хэрэглэснээр амжилтанд хүрч байсныг баримтаар нотлохыг оролдсон юм. Тэрээр эртний Грек, Ромын үеэс эхлээд Дундад зууны болон Сэргэн мандалтын үеийн Италийн хот-улсуудын улс төрийн ээдрээтэй амьдралын баялаг түүхийн жишээн дээр тулгуурлан амжилтанд хүрсэн ба алдаа гарган бүтэлгүйтсэн улс төрийн удирдагчдын талаар дүгнэн бичсэн билээ.

Зарим судлаачид Макиавеллиг улс төрийн эрх мэдлээ сэргээх, Флоренцийн шинэ удирдлагад үнэлэгдэх зорилгоор **“Эзэн дээдэс”**-ийг бичих болсон хэмээн үздэг. Үүний жишээг ч түүний бүтээлийн удиртгал буюу **“Никколо Макиавеллигээс”** гэсэн хэсгээс харж болно. *“Төр баригчдын өршөөл ивээлд орохыг хүссэн хүмүүс ихэвчлэн хамгийн үнэ цэнэтэй зүйлээ юм уу, хамгийн их таалагдаж таашаал өгөх зүйл, тухайлбал, хүлэг морь, зэр зэвсэг, хоргой торго, эрдэнийн чулуу болон ихэс дээдсийн сүр жавхаанд тохирох элдэв гоёл чимэглэл өргөн барьдаг. Харин миний бие эзэн дээдэс танд чин үнэнчээ батлан гэрчлэхийг хичээнгүйлэн хүсэхдээ өнгөрсөн үеийн түүхийг гүнзгий үзэж судалсан туршлага дээрээ үндэслэн, эдүгээ цагийн хичээл зүтгэлээр олж мэдсэн, агуу хүмүүсийн үйл хэрэгт хамааралтай мэдлэгээс өөр үнэ цэнэтэй, эрхэм дээд зүйл олоогүй болохоо илэрхийлье. Сурсан мэдсэн болгоноо удаан хугацаанд ихэд хичээнгүйлж эргэцүүлэн тунгаасны үр дүнд бодол санаагаа төвлөрүүлж бэсрэг бүтээл болгоод Гэгээн дээдэс танд бэлэг болгон хүргүүлэв”*<sup>59</sup> хэмээснээс үзэхэд үнэхээр тийм дүгнэлт хийж болох мэт. Гэвч энэ нь туйлын үнэнд нийцэхгүй болов уу. Учир нь *“Миний хувьд эх орон минь амь наснаас минь илүү үнэ цэнэтэй”* хэмээн бичиж үлдээсэн Макиавелли юун түрүүнд нэгдсэн нэг удирдлагатай хүчирхэг Итали орныг дахин байгуулагдахыг хүсэж байсан эх оронч үзэлтэн байсан болохыг түүний бүтээлийн олон хэсгээс олж харж болно. **“Итали орныхоо эзэн болж, зэрлэгүүдийн савраас түүнийг чөлөөлөх уриа”** хэмээх 26-р бүлэгт Итали орон тархай бутархай, нэгдсэн нэг удирдлагагүйн улмаас сулран доройтсоныг онцлоод Итали орныг аврах итгэл найдварыг Медичийн гэр бүлд тавьж байгаагаа уламжилж, *“Танай ялгуусан гэр*

<sup>58</sup> Miles J. Unger, *Machiavelli: A Biography* (New York: Simon and Schuster, 2011), 2.

<sup>59</sup> Н. Макиавелли, *Эзэн дээдэс*, орч. Ч.Баатар (Улаанбаатар: Монсудар, 2015), vii-viii.



бүлийн тугийн намираан дор манай эх нутаг, улс орон өнгөжин жавхаажиж, түүний залуур дор Петраркийн хэлсэн:

*Итали зүрх сэтгэл дэх*

*Эр зориг үхээгүй болохоор*

*Хуй салхи мэт эрчлэн довтолж*

*Хоромхон зуур тулааныг дуусгана гэсэн үгийг хэрэгжүүлэн биелүүлэхийн тулд их хэргийг бүтээдэг эр зориг, итгэл найдвартайгаар энэ үүргийг өөртөө авах болтугай”<sup>60</sup> гэсэн уриагаар өөрийн бүтээлээ өндөрлүүлжээ.*

Тэгэхээр түүний энэхүү бүтээлийг бичих болсон үндсэн зорилго нь Флоренцийн хот улсын сулрах болсон учир шалтгааныг илрүүлж асуудлыг шийдвэрлэх арга зам олох, мөн улс төрийн суурь зарчмууд болон бодит байдлыг задлан шинжлэх замаар дотооддоо тогтвортой, гадны халдлагаас өөрийгөө хамгаалах чадвартай Бүгд Найрамдах Засаглалын хэлбэрийн улсыг байгуулахад оршиж байв. Макиавелли авилгад идэгдэн хүч нь суларсан Флоренцийг эрс өөрчлөх замаар Периклийн үеийн Афин эсвэл Ромын Бүгд Найрамдах Улс лугаа адил **“нэгдсэн, ёс суртахууны хувьд шинэчлэгдсэн, жинхэнэ хүчирхэг улс”**-ыг байгуулахыг зорьсон бөгөөд үүний тулд эртний улсуудын удирдагч нарт ихэд үнэлэгдэж байсан хүч чадал, ур чадвар, эр зориг, итгэл найдвар, алдар нэр, нийтийн ашиг тусын төлөөх иргэдийн итгэл үнэмшил зэрэг чанаруудыг чухалчилсан байна.

Макиавеллигийн үзсэнээр ихэнх хүмүүс “аймхай хулчгар, олзонд дуртай, туйлбаргүй, богино ухаантай, хоёр нүүрт хууран мэхлэгч, ов зальтай, аялдан дагагсад ба бусдын буяныг үл санагсад” бөгөөд ийм нөхцөлд ёс суртахууны хэм хэмжээг баримталдаг эзэн хаад мөхөлд амархан хүрдэг. Иймийн учир урт удаан хугацаанд эрх мэдлээ хадгалж үлдэхийг хүсвэл эзэн дээдэс энэрэнгүй зөөлөн сэтгэлт байхаас татгалзах ёстой хэмээжээ.

*Эзэн дээдэс..... улс орноо хүчирхэг хэвээр нь хадгалж үлдэхийн тулд зөөлөн сэтгэл, хүнлэг энэрэнгүй байдал, шударга нигүүлсэнгүй чанар, шашины үнэт зүйлсээс татгалзах ёстойг ойлгох болно.....тэрбээр тодорхой цаг мөчийг хүртэл уужим зөөлөн сэтгэлт байх хэдий ч шаардлагатай гэж үзвэл харгис ширүүн зан хэрэгтэйг ухаарах болно. Нүгэл хилэнцэт хүний ертөнцөд эзэн дээдэс гэгээн ариун байхын оронд эрх мэдэл, хүч чадлыг гартаа төвлөрүүлэн, дайсан этгээдүүдтэй ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг үл харгалзан хатуу ширүүн аргаар өршөөлгүй тэмцэх хэрэгтэй<sup>61</sup> хэмээн Макиавелли зөвлөжээ.*

Судалгааны ажлынхаа үр дүнд тэрээр аливаа удирдагчийн амжилтанд хүрэхэд нөлөөлдөг 3 хүчин зүйлийг тодорхойлсон байна.

Эхний хүчин зүйл нь **Virtù** буюу эр зориг, эрс шийдэмгий байдал. Энэхүү чанарыг эзэмшиж буй эзэн дээдэс нь ухаалаг, чадварлаг нэгэн байна. Тэрээр олон

<sup>60</sup> Мөн тэнд. 133-р тал.

<sup>61</sup> Stewart Patrick, “Machiavelli: still shocking after 5 centuries.” The National Interest, November 20, 2014, <https://nationalinterest.org/commentary/machiavelli-still-shocking-after-five-centuries-9126>.

нийтийг өөрийн араас дагуулах увидастай, хүч чадавх нэр нөлөө бүхий удирдагч байхыг хүсэн тэмүүлэх ба энэ тохиолдолд эрх мэдэл үргэлж түүнийг дагах болно.

Удаах хүчин зүйл нь **Necessita** буюу шаардлагатай хэмээн үзсэн зүйлийг хийх хүсэл эрмэлзэл. Уг чанар нь нүгэлээс үл хамааран нэн чухал, шаардлагатай хэмээн үзсэн зүйлээ хийх хүсэл тэмүүлэл бөгөөд энэхүү чанарыг эзэмшиж буй эзэн дээдэс нь ёс суртахууны хүлээснээс ангид байх ёстой болно. **Virtù** болон **Necessita** хэмээх 2 чанарын үндсэн ялгаа нь юунд оршиж байна вэ гэхээр эхний чанарыг эзэмшиж буй удирдагч нь дайсныг дайсан болохоос нь өмнө ямар ч эргэлзээгүйгээр устгах явдал бол дараагийн чанарыг эзэмшиж буй удирдагч нь дайсныг дайсан болсон хойно нь эргэлзэж тээнэгэлзэлгүйгээр устгахад оршино.

Сүүлийн хүчин зүйл нь **Fortuna** буюу аз хийморьтой байх явдал. Аз хийморь гэдэг нь нь Макиавеллигийн үзсэнээр “эм хүн лугаа адил” бөгөөд түүнийг хяналтандаа байлгахын тулд байнга “зодож байх” шаардлагатай. Аз хийморь гэдэг нь хувь заяаны төөрөг, хэрэв аз хийморийг **Virtù** буюу эр зориг, эрс шийдэмгий зантай “Эзэн дээдэс” хянаж байхгүй бол өөр нэгэн удирдагчийн мэдэлд очих болно. Улс төр нь үйл ажиллагаа болохоос ёс суртахууны зан үйл биш, тийм учир ёс зүйтэй улс төрч бус харин эрс шийдэмгий, эр зоригтой (**Virtù**), шаардлагатай гэж үзсэн зүйлээ хийж хэрэгжүүлэх чадвартай (**Necessita**) улс төрч л аз хийморьтой (**Fortuna**) байж амжилтанд хүрсэнийг Макиавелли судалгаагаараа харуулсан юм.

Персийн хаан Кир, Сиракузын хаан Агафокл, Ромын эзэн хаан Каракаллаас эхлээд Францын эзэн хаан XII Людовик, Ромын Пап VI Александрын хүү Чезаре Боржа хүртэлх олон хаад, эзэн дээдэс нараар жишээлэн ирээдүйн хаадад өгөх өөрийн зөвлөгөөг дараах байдлаар боловсруулжээ.

Хамгийн чухал, нэн түрүүнд анхаарах зүйл бол эзэн дээдэс өөрийн эрх мэдлийг хадгалж үлдэх, улс орныхоо аюулгүй байдлыг хангахын төлөө бүхнээ зориулах ёстой. Бусад хаадыг хүчирхэгжүүлэх, илүү хүчтэй улстай холбоотон болохоос ямагт сэргийлэх хэрэгтэй.

Хоёрдугаарт, “эзэн дээдэс, хаад ноёдын эзэмшвэл зохих цорын ганц урлаг” болох дайны урлагт төгс суралцах шаардлагатай. Хангалттай хэмжээний зэр зэвсэг эзэмшиж цэрэг армия байнгын дайны бэлэн байдалд байлгаснаар л гадны түрэмгийлэгчид төдийгүй дотоодын өрсөлдөгчдөөс өөрийн улс орныг авран хамгаалж чадна. Энх тайван бол түр зуурын ойлголт ба ард иргэд, цэрэг арми, улс орны сэтгэл зүйг шинэ дайнд бэлтгэх боломж юм. “Шударга дайн” хэмээх ойлголт үгүй бөгөөд хэнд дайн хэрэгтэй байна түүнд дайн шударга зүйл.

Гуравдугаарт, улс орноо удирдах үйл хэрэгтээ ов заль, хууран мэхлэлтийг гол хэрэгсэлээ болгон ашигла. Жинхэнэ зорилгоо нууж хаацайл, зөвхөн өөрт ашигтай тохиолдолд хэлсэн үгэндээ хүр. Бусад нь чамд үнэнч гэдэгт бүү итгэ, зусарч бялдууч туслахуудаар өөрийгөө хүрээлүүлэх хэрэггүй, зөвхөн цөөн тооны ухаалаг шадар туслахуудыг л өөртөө ойртуул. Ямагт бусадтай зөвлөлдөх хэрэггүй, шийдвэрийг зөвхөн өөрөө гарга, цөөн тохиолдолд шадар зөвлөхүүдийнхээ саналыг сонс.

Эцэст нь нөхцөл байдлаас шалтгаалан уужим энэрэнгүй сэтгэл болон догшин хэрцгий зан төлөвийн алийг нь ч хэрэглэхээс бүү таггалз. Эзэн хаадыг хайрладаг ч, бас айдаг байвал нэн сайн гэж ярилцдаг ч хайр айдас хоёроос сонгоход хүрвэл айдсыг сонгох хэрэгтэй юм.<sup>62</sup> Эзэн хаан олон цэргээ удирдан яваа үедээ харгис хэрцгий гэсэн нэр зүүхээсээ огтхон ч болгоомжлох хэрэггүй, учир нь хатуу чанд, харгис хэрцгий гэсэн нэр зүүхгүй бол их цэргийн нэгдэл нягтрал, байлдааны чадварыг зохих түвшинд байлгаж үл чадна.<sup>63</sup> Хаан хүн бүх араатнуудын дундаас арслан, үнэг хоёрыг сонгон авч тэдний зан чанарыг дууриах хэрэгтэй. Арслан хавхнаас айдаг бол үнэг чононоос айдаг. Хаантан хавхнаас тойрч гарч чаддаг болохын тулд үнэгтэй адилхан, харин чононуудыг айлгадаг байхын тулд арслантай адил байх ёстой. Дандаа арслан шиг байх юм бол хавхыг анзаарахгүй байх талтай.<sup>64</sup> Гэхдээ эзэн дээдэс ямар ч тохиолдолд ард иргэддээ үзэн ядагдах сэтгэлийг төрүүлэхгүй байх нь чухал юм.

Дээрх зөвлөгөөнүүдээс харахад Макиавеллиг ёс суртахууны хэм хэмжээг уландаа гишгэсэн, улс төр дэх худал хуурмаг, бохир заваан, хатуу ширүүн, шударга бус байдлыг өөгшүүлсэн ёс зүйгүй хүн мэтээр дүгнэж болох талтай. Олон судлаачид түүнийг **“Тирануудын зөвлөгч”** хэмээн үздэг бол зарим судлаачид түүнийг эсрэгээр нь дүгнэсэн байдаг. Тухайлбал Стьюарт Патрик *““Эзэн дээдэс”-ийг бичсэнээр улс төрийн амьдрал дахь бодит нөхцөл байдлыг бусдад ойлгогдохоор ил тод, тунгалаг болгосон билээ. Ийм маягаар Макиавелли улс төрийн удирдлагын анхаарч байвал зохих суурь ойлголтуудын талаар чухал зөвлөгөөг ирээдүйн улс төрийн шийдвэр гаргачдад өгсөн”*<sup>65</sup> хэмээн дүгнэсэн бол Италийн эрх зүйч Оксфордын их сургуулийн профессор Альберико Жентили *“Түүний зорилго нь тираныг бэлдэх биш, харин түүний бүхий л нууцыг ил болгоход оршсон”*<sup>66</sup> хэмээн Макиавеллиг үнэлжээ. Гэвч өнөөдрийг хүртэл Монголын болон гадаадын олон арван судлаачид түүнийг улс төрийг ёс суртахуунаас ангид байхыг номлосон хэмээн нотолж байна. Тухайлбал Монголын ШУА-ийн Философийн хүрээлэнгийн улс төрийн философич Д.Болд-Эрдэнэ өөрийн бүтээлдээ *“тэрээр улс төр, ёс зүйн философи сэтгэлгээнд “ёс суртахуунд баригдахгүй улс төр” –ийн үзэл санааг дэвшүүлсэн ба улс төрд ёс суртахуун хэрэгтэй ч, аргагүй үе тохиоход эзэн захирагч хүн ёс суртахуунд баригдахгүйгээр бүхнийг хийх ёстой болдог”*<sup>67</sup> хэмээн нотолсон.

<sup>62</sup> Н. Макиавелли, *Эзэн дээдэс*, орч. Ч.Баатар (Улаанбаатар: Монсудар, 2015), 86.

<sup>63</sup> Мөн тэнд. 87-р тал

<sup>64</sup> Н. Макиавелли, *Принц: засаглахуйн шастир*, орч. Ц.Наранбат (Улаанбаатар: Эзэнсүлд, 2013), 133-134.

<sup>65</sup> Stewart Patrick, “Machiavelli: still shocking after 5 centuries,” *The National Interest*, November 20, 2014, <https://nationalinterest.org/commentary/machiavelli-still-shocking-after-five-centuries-9126>.

<sup>66</sup> Alberico Gentili, quoted in Harvey C. Mansfield, *Introduction to Niccolo Machiavelli* (Chicago: University of Chicago, 1988), xix.

<sup>67</sup> Д.Болд-Эрдэнэ, *Улс төрийн философи* (Улаанбаатар: Тод бичиг, 2015), 262.

## ДҮГНЭЛТ

Хүйтэн дайны төгсгөлд олон улсын харилцааны цөөнгүй судлаачид Ялта-Потсдамын системийн дараа тогтсон 1990-ээд оны үеийн “Дэлхийн дэг журам”-ыг олон улсын харилцаанд эгнэгт энх тайван тогтох цаг үеийн эхлэл хэмээн дүгнэж улсуудын хоорондын харилцан хамаарал ихсэхийн хирээр олон улсын харилцааны сөргөлдөөнт байдал эцэс болохыг нотлохоор зорьж байсан. Зарим судлаачид үндэсний ашиг сонирхолоо дээдэлсэн Үндэстэн-улсуудын<sup>68</sup> хоорондын систем буюу Олон Улсын Харилцааны Вестфалийн эрин үед төгсгөл ирсэнийг судалгааны ажлын үр дүнгээрээ батлахаар оролдож байсан билээ. 2001 оны 9 сарын 11-ний үйл явдлын дараа ч тэр неолибераль ба даяаршилын онолын судлаачид дэлхий хавтгайрах үйл явцад тулгуурлан хүн төрөлхтөнийг дайн тулаангүй ирээдүй хүлээж буйд баг итгэлтэй байсан ба энэхүү итгэл үнэмшлийнхээ хүрээнд олон арван ном зохиол, судалгааны бүтээл хэвлүүлэн гаргасан байдаг.

Гэвч АНУ-ын либераль үнэт зүйл гэхээс илүүтэй шашны хэт туйлширсан, суурь үзлийг үнэт зүйлээ болгосон исламын шашинт улсуудын гадаад бодлогодоо баримталж буй байр суурь, БНХАУ-ын эдийн засгийн хурдацтай хөгжил түүнийг дагасан нөлөөний хүрээгээ тэлэх бодлого, нэн ялангуяа ОХУ-ын Евразийн геополитикийн ашиг сонирхолд тулгуурласан геостратегийн бодлого зэрэг нь дэлхийн улс төрийн бодлогод хүч чадавх, байр суурь, нөлөөний төлөөх тэмцлийг өдөөснөөр олон улсын харилцаанд дахин эмх замбараагүй байдлыг бий болголоо. АНУ-ыг дахин хүчирхэгжүүлэх зорилго бүхий Д.Трампын гадаад, дотоод бодлого, Хойд Солонгосын Ким Чын Уны цөмийн хөтөлбөрийн үзэл баримтлал, БНХАУ-ын дарга Сы Зин Пиний эдийн засаг, улс төрийн гадаад бодлогын ирээдүйн зорилго, ОХУ-ын ерөнхийлөгч В.Путиний геополитик, цэрэг стратегийн бодлого зэрэг нь өнөөдрийн олон улсын харилцааны гол анхаарал татсан сэдэв болоод байна.

Олон улсын харилцааны энэхүү нөхцөл байдлыг ажиглахад орчин цагийн улс төрийн шийдвэр гаргагчдын гадаад бодлого, улс төрийн үйл ажиллагаанд “**үндэсний ашиг сонирхол**” маш чухал хүчин зүйл хэвээр байгааг харж болох бөгөөд эрх мэдэл, хүч чадавхаа нэмэгдүүлэх нь эдгээр улсын хувьд нэн чухал гэдэг нь эргэлзээгүй болж байна. Улс орноо удирдах, олон улсын харилцаанд эрх мэдлээ хадгалах, хүч чадавхаа нэмэгдүүлэх үйл хэрэгтээ улс төрийн шийдвэр гаргагчид “**ёс суртахууны хэм хэмжээг баримтлах ёсгүй, харин ёс суртахуунтай мэт харагдах ёстой**” хэмээх Н.Макиавеллигийн зөвлөгөөг сайтар дагаж мөрдөж байна. Ингэснээр өнөөгийн дэлхийн улс төрийн бодлого, олон улсын харилцаанд өнгөрсөн зууныг хүртэл хадгалагдаж ирсэн эрх мэдлийн төлөө шударга ёсыг үгүйсгэдэг, ёс суртахууны хэм хэмжээг үл ойшоосон, эрх зүйн суурь зарчмуудыг дагаж мөрдөх гэхээс илүүтэй хүч чадавхийг чухалчилсан улс төрийн бодлого ноёрхох боллоо. Үүнээс улбаалаад олон улсын харилцааны судалгаанд сонгодог реализмын онолын сургуулийн байр суурь дахин сэргэх хандлага бий болсоныг өнөөгийн олон улсын харилцааны олон арван судалгааны ажлуудаас харж болно.

<sup>68</sup> Nation State

Иймээс сонгодог реализмын уламжлалт бүтээлүүдийг судлан шинжилж олон улсын харилцааны үйл явдалд дүн шинжилгээ хийх хандлага судлаачдын дунд түгээмэл болж байна.

Н.Макиавеллигийн “Эзэн Дээдэс” хэмээх энэхүү бүтээл нь улс төрийн шийдвэр гаргагчдад өгсөн үнэтэй зөвлөгөө төдийгүй улс төрийн үйл явцийн бодит дүр төрхийг ил болгосон чухал бүтээл юм. Энэхүү бүтээлийг судлаачид өөр өөрсдийнхөөрөө дүгнэн цэгнэж байдаг бол улс төрийн шийдвэр гаргагчид энэ бүтээлийг уншсан эсэхээс үл хамааран ёс суртахууны хэм хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг болгодоггүй жишээг дотоод, гадаадын улс төрийн үйл амьдралаас олноор харж болно.

Улс төрчид Макиавеллигийн бүтээлээс санаа аван **“улс төрд зорилго нь аргаа зөвтгөдөг”** хэмээх зүйрлэлийг хэрэглэдэг гэхээс илүүтэй Н.Макиавелли улс төрийн амьдралын мөн чанар тэр дундаа улс төрийг ёс суртахуунгүй болохыг, шударгаар явсан улс төрчид амжилтанд хүрдэггүйг, хууран мэхлэх арга ажиллагаа бол улс төрийн шийдвэр гаргалтын гол хэрэгсэл болж байдгийг хөндлөнгөөс үнэлж дүгнэсэн байх өндөр магадлалтай. Эцэст нь дүгнэхэд аль ч утгаараа тэр улс төр гэдэг хожоо гаргахын тулд шударга байх боломжгүй тоглоом гэдэг нь Н.Макиавеллигийн “Эзэн Дээдэс” хэмээх бүтээлээс ойлгомжтой болж буй тул олон улсын харилцаа, дэлхийн улс төрийн бодлогод ёс суртахуунд суурилсан “үүрдийн энх тайван” тогтох боломжгүй харин ч эсрэгээрээ эрх мэдэл, эд баялагийн төлөөх ёс суртахуунгүй улс төрчдийн тэмцэл үргэлжилсээр байх болно гэдэгт бат итгэлтэй байна.

**НОМ ЗҮЙ:**

1. Д.Болд-Эрдэнэ, *Улс төрийн философи*. Улаанбаатар: Тод бичиг, 2015.
2. Н.Макиавелли. *Принц: засаглахуйн шастир*. орч. Ц.Наранбат. Улаанбаатар: Эзэнсүлд, 2013.
3. Н.Макиавелли. *Эзэн дээдэс*. орч. Ч.Баатар. Улаанбаатар: Монсудар, 2015.
4. П.Мягмардорж."Фукидидын "Пелопонессийн дайны түүх" ба улс төрийн реализм". ХИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. УБ. 2016 он.
5. Ashworth, Lucian M. "Did the Realist-Idealist Great Debate Really Happen? A Revisionist History of International Relations." *Sage Journals* 16, no. 1 (2002): 33-51. doi: 10.1177/0047117802016001004
6. Booth Ken, Cox Micheal., and Timothy Dunne. *The eighty years crisis: international relations: 1919-1999*. Cambridge: Cambridge University Press, 1998.
7. Harrison, Robert P. "What can you learn from Machiavelli?" Yale Insights. January 11, 2011. <https://insights.som.yale.edu/insights/what-can-you-learn-machiavelli>.
8. "Jared Diamond: By the book." New York Times. <https://www.nytimes.com/2013/01/20/books/review/jared-diamond-by-the-book.html>.
9. Lahtinen, Mikko. *Politics and Philosophy: Niccolo Machiavelli and Louis Althusser's Aleatory Materialism*. Leiden: Brill, 2009.
10. Mansfield, Harvey C. *Introduction to the Prince by Niccolo Machiavelli*. Chicago: University of Chicago Press, 1988.
11. Unger, Miles J. *Machiavelli: A Biography*. New York: Simon and Schuster, 2011.
12. Patrick, Stewart. "Machiavelli: still shocking after 5 centuries." The National Interest. November 20, 2014. <https://nationalinterest.org/commentary/machiavelli-still-shocking-after-five-centuries-9126>.
13. Hillary Clinton reviews Henry Kissinger's "World Order". The Washington Post. September 4, 2014